



## НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 12 сарын 11 өдөр

Дугаар А/581

Улаанбаатар хот

“Сүхбаатар дүүргийн 248 дугаар цэцэрлэгийн”  
данс бүртгэлд хөрөнгө бүртгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4 дэх заалт, 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалт, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын даргын 2024 оны А/481 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 12 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Бүгд найрамдах Турк улсын хамтын ажиллагаа, зохицуулах агентлаг ТИКА-ын хандивласан нийт 11,511,921.30 (арван нэгэн сая таван зуун арван нэгэн мянга есөн зуун хорин нэгэн төгрөг гучин мөнгө) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан эргэлтийн бус хөрөнгийг данс бүртгэлд бүртгэн авахыг Сүхбаатар дүүргийн 248 дугаар цэцэрлэг (Ж.Энхзул)-т зөвшөөрсүгэй.

2. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Сүхбаатар дүүргийн 248 дугаар цэцэрлэг (Ж.Энхзул)-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В.ОЮУМАА



Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны 11 дугаар сарын 11-ны өдрийн А/СЭ/1 дугаар тушаалын хавсралт

Бүртгэлд авах хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Сүхбаатар дүүргийн 248-р цэцэрлэг

| Д/д                           | Эд хөрөнгийн нэр | Марк дугаар | Ашиглалт ад авсан он | Чанар байдал | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Бүртгэлийн анхны үнэ /төгрөгөөр/ |               | Хөрөнгө оруулалтын шийдвэр болон хандивлагчийн нэр | Хөрөнгийн эх үүсвэр |
|-------------------------------|------------------|-------------|----------------------|--------------|-------------|------------|----------------------------------|---------------|----------------------------------------------------|---------------------|
|                               |                  |             |                      |              |             |            | нэгжийн үнэ                      | нийт дүн      |                                                    |                     |
| 1                             | Зурагт           | Haier       | 2024                 | сайн         | ш           | 1          | 2,700,744.00                     | 2,700,744.00  | ТИКА                                               | Хандив              |
| 2                             | Систем хөгжим    | Sony        | 2024                 | сайн         | ш           | 1          | 1,856,761.50                     | 1,856,761.50  | ТИКА                                               | Хандив              |
| 3                             | Тоос сорогч      | Samsung     | 2024                 | сайн         | ш           | 1          | 675,186.00                       | 675,186.00    | ТИКА                                               | Хандив              |
| Машин, тоног төхөөрөмжийн дүн |                  |             |                      |              |             |            |                                  | 5,232,691.50  |                                                    |                     |
| 1                             | Тайз             | Заалны      | 2024                 | Сайн         | ш           | 1          | 5,063,895.00                     | 5,063,895.00  | ТИКА                                               | Хандив              |
| 2                             | Вандан сандал    | Заалны      | 2024                 | Сайн         | ш           | 4          | 303,833.70                       | 1,215,334.80  | ТИКА                                               | Хандив              |
| Тавилга, эд хогшлын дүн       |                  |             |                      |              |             |            |                                  | 6,279,229.80  |                                                    |                     |
| НИЙТ ДҮН                      |                  |             |                      |              |             |            |                                  | 11,511,921.30 |                                                    |                     |